





11 ДҮГЭЭР АНГИЙН ГАЗАРЗҮЙН ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР

Хугацаа: 60 мин

- Юмс үзэгдлийн бүтэц бүрэлдэхүүн буюу бүхэл зүйлийн доторх хуваагдсан хэсгүүдийг үзүүлэхэд диаграмм хэрэглэдэг. \1 оноо\
 - A. Цацраган диаграмм B. Хүн ам суварга C. Тойргон диаграмм D. Цэгэн диаграмм
- XXI-ээр тэргүүлж буй улсад аль нь орохгүй вэ? \1 оноо\
 - A. Норвеги B. Австраль **C. Швед** ~~F. Дани~~ ~~D. Алжир~~
- Хүн амын тоо, хувь, насны болон хүйсийн бүлгийг нэгэн зэрэг илэрхийлэх диаграмм аль нь вэ? \1 оноо\
 - A. Цацраган диаграмм B. Хүн ам суварга C. Бүлэглэлт диаграмм D. Тойргон диаграмм
- Даяаршлын КОФ индекс багатай орныг сонгоно уу?
 - A. Нидерланд B. Ирланд C. АНУ D. Эритрей
- Хүн амын дундаж наслалт багатай орныг сонгоно уу? \1 оноо\
 - A. Украйн B. ОХУ C. Япон D. Судан
- Зэсийн уурхай байгуулахын тулд аль хүчин зүйлийг чухалчлах вэ? \1 оноо\
 - A. Эрчим хүч B. Ажиллах хүч C. Зах зээл D. Түүхий эд
- Хүнс тэжээл, бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх зорилгоор зориудаар ургамал , үр тариа тариалах , мал амьтныг үржүүлэх, тэдгээрээс авах түүхий эдээр анхан шатны боловсруулалт хийх ажиллагааг гэж тодорхойлж болно. \1 оноо\
 - A. Газар тариалан **B. Ү.** Хөдөө аж ахуй C. В. Мал аж ахуй D. F. Үйлдвэрлэл
- Зам тээврийг хөгжүүлэхэд байгалийн аль хүчин зүйл төдийлөн чухал биш вэ? \1 оноо\
 - A. Рельеф B. Ус зүй C. Уур амьсгал D. Ургамал, амьтан
- Хамгийн хямд зардлаар хол зайд их ачаа барааг тээвэрлэх боломжтой тээврийн салбар\1 оноо\
 - A. Агаарын тээвэр B. Усан замын тээвэр C. Төмөр замын тээвэр D. Авто замын тээвэр
- Дэлхий дээрх агаарын дундаж температур өөрчлөгдөх үйл явц бол юм. \1 оноо\
 - A. Дэлхийн дулаарал B. Температурын инверс
 - C. Уур амьсгалын өөрчлөлт D. Температур нэмэгдэлт
- Экологийн ул мөр аль бүс нутагт их байна вэ? \1 оноо\
 - A. Зүүн өмнөд Ази B. Дорнод Сибирь C. Бразилийн нам дор газар D. Төв Африк
- Google Earth программ ашиглан дараах алхамуудаас гүйцэтгэж болохгүйг сонгоно уу? \1 оноо\
 - A. Аялалын маршрут гаргах B. Хотуудын байршлын мэдээлэл авах
 - C. Газар ашиглалтын өөрчлөлтийг гаргах D. ~~M~~малын тооны өөрчлөлт судлах
- Дараах улсуудаас хөгжингүй орныг сонго уу. \1 оноо\
 - A. Бразил B. Монгол C. Герман D. Конго
- Хөгжингүй орныг тодорхойлох үзүүлэлт аль нь вэ? \1 оноо\
 - A. Хүн амын тоо их B. ХАА-н эдэлбэр газар C. 1 хүнд ногдох ДНБ их
 - D. Нутаг дэвсгэр том
- Дэлхийн нийт хүн амын 18.8% нь улсад амьдарч байна. /2 оноо/
 - A. Япон B. Хятад C. Индонез D. Америк
- Хөгжиж буй ихэнх орны хүн амын суварга хэлбэртэй. /2 оноо/
 - A. Залуу B. Хөгшин C. Идэр D. Хэвийн
- Япон орны 2018 оны хүн амын суварга аль нь вэ? /2 оноо/
 - A. 
 - B. 
 - C. 

18. Негр буюу хар арьстан хаана ихээр амьдардаг вэ? /2 оноо/
 А. Африкийн хойд хэсэг В. Африкийн өмнөд зах С. Африкийн төвөөр D. Ази
19. Дараах байгалийн нөхцөл байдлаас алинд нь хүн ам ихээр суурьших вэ? /2 оноо/
 А. Өндөр уулархаг газар В. Далайн эрэг орчмоор С. Эх газрын төвд D. Нуурын эргээр
20. Хөрс ургамлыг услах дэвшилтэт техник ,технологийг ашиглах ,суваг шуудуу ухах зэргээр тариалангийн газрыг усаар хангах үйл ажиллагааг юу гэж нэрлэх вэ? /1 оноо/
 А.Усжуулалт В.Газар тариалан С.Чийгшүүлэлт D.Усан хангамж
21. Үйлдвэрийн аргаар гаргаж авсан химийн бодисын найрлага бүхий бордоо , хортон шавжны хор зэргийг хэрэглэхгүйгээр газар тариалан , мал аж ахуй эрхлэхийг гэнэ. /1 оноо/
 А.Ногоон хэрэглээ В. Эко үйлдвэрлэл С.Эрүүл тариалалт D.Органик Ферм
22. Сони, Шарп, Тошиба зэрэг корпорациуд юуны чиглэлийн үйлдвэр вэ? /1 оноо/
 А. Цахилгаан, техник В. Автомашин С. Станц D. Төмөрлөг
23. Суэцийн суваг гаргасны давуу тал юу вэ? /2 оноо/
 А. Урт замыг товчлох В. Бараа бүтээгдэхүүний эргэлт ихсэх
 С. Даяаршил бий болох D. Дээрх бүгд
24. Дараах диаграммыг ажиглаад үйлдвэр хэрхэн ажилласаныг сонгоно уу? /2 оноо/



- А. Алдагдал ихтэйшигтай
 В. Бага зэрэг ашигтай
 С. Их ашигтай
 D. Ашиг, алдагдал 2 нь тэнцүү

25. Хөгжиж буй орнуудын худалдааны гол шинжийг нэрлээрэй?
 А. Түүхий эдээ гадаадад гаргаж, бэлэн бүтээгдэхүүн импортлоно
 В. Бэлэн бүтээгдэхүүн гаргаж, түүхий эд импортлоно
 С. Түүхий эд болон бэлэн бүтээгдэхүүн импортлоно.
 D. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн экспортлоно
26. Дараах зургийг ажиглан байгаль орчинд тулгамддаг ямар асуудлыг илэрхийлсэнийг сонго. /2 оноо/



- А. Агаарын бохирдол, утаа
 В. Хүчлийн бороо орох нөхцөл
 С. Далайн усны түвшин нэмэгдэх
 D. Озоны давхаргын цоорол, нимгэрэлт

27. Зарим хаягдал бүтээгдэхүүний байгальд уусч алга болох хугацааг харгалзуулаарай. /2 оноо/
 1. Шил a. 1000 жил
 2.Хуванцар аяга b. 4000 жил
 3.Нэг удаагийн аяга таваг c. 400 жил
 4. Усны хуванцар сав. d. 500 жил
 А. 1b2a3d4c В. 1b2d3ca4ae С. 1d2a3c4b D. 1a2b3d4c

28. Дэлхийн дулаарлын шууд биш үр дагавар аль нь вэ? /2 оноо/
 А. Далайн усны түвшин нэмэгдэнэ ВБ. Биологийн төрөл зүйл мөхнө
ВС. Цэвдэг гэснэ DF. Өлсгөлөнд нэрвэгдэнэ Д-Озоны нимгэрэлт

29. Туул голын аль хэсэгт гол хамгийн их бохирдсон байна вэ? /2 оноо/



- A. Эхэн хэсэгтээ
- B. Заамар орчимд
- C. Яармаг орчимд
- D. Тэрэлж орчимд

30. Дараах хотуудаас альфо зэрэглэлийн хотыг сонгоно уу? /1 оноо/

- A. Улаан баатар
- B. Бээжин
- C. Лондон
- D. Стамбул


31. Ажлын байр хайх, амьдралын нөхцлөө сайжруулахын төлөө олноор гадаад руу шилжих үйл явцыг юу гэж нэрлэдэг вэ? /2 оноо/

- A. Гадаад шилжих хөдөлгөөн
- B. Дотоод шилжих хөдөлгөөн
- C. Дүрвэгсэд
- D. Түр зуурын хөдөлгөөн
- E. Ажиллах хүчний шилжилт

Formatted: Indent: First line: 0 cm

Formatted: Font: (Default) Arial

32. 2-ын тоогоор хотын ямар функцийг тэмдэглэсэн байна вэ? /2 оноо/




- A. Бага орлоготой иргэдийн хороолол
- B. Төвийн бизнес дүүрэг
- C. Орлого өндөртэй иргэдийн хороолол
- D. Худалдаа, хөнгөн үйлдвэр
- E. Хотын захын нүүж ирэгсдийн бүс

33. Үйлдвэрлэлийн гуравдагч хэв шинжид хамаарах салбар аль нь вэ? /2 оноо/


- A. Уул уурхай олборлолт
- B. Үйлчилгээ
- C. Түүхий эд бэлтгэх
- D. Техник технологи

34. Дараах зурагт зүүн Ази, зүүн өмнөд Азийн зарим орны чийглэг бүсэд тариалдаг ургамлын тархалтын зураг үзүүлжээ. Зураг ямар тариалалтыг дүрслэн харуулсан байна вэ? /2 оноо/



- A. Цагаан будааны тариалан
- B. Улаан буудайн тариалан
- C. Усан үзмийн тариалан
- D. Хөвөнгийн тариалан

35. Австралийн аж үйлдвэрийн экспортын хэмжээг харуулсан зургаас БУРУУ хариултыг олоорой. /2 оноо/



- A. Хөдөө аж ахуйн экспортын хэмжээ огцом буурчээ
- B. Австрали нь нүүрсний экспортоор дэлхийд тэргүүлдэг тул уул уурхайн экспорт 20%-аар өссөн байна.
- C. Аж үйлдвэрийн экспорт ихэссээр байна, сээд буурчээ
- D. Үйлчилгээний экспорт 50% өссөн байна.

Formatted: Font: 11 pt


Formatted: Font: 11 pt

36. Эко аялал жуулчлал хөгжүүлснээр тухайн бүс нутагт бий болно. /1 оноо/

- A. Орон нутгийн иргэд орлоготой болно
- B. Байгаль унаган төрхөө алдахгүй
- C. Байгаль хайрлах хамгаалах үзэлтэй болно
- D. Дээрх бүгд

37. 2023 онд Монгол улсын хүн ам 3,3 сая, жилийн дундаж өсөлт 1.4 хувь байсан бол 2030 онд хүн ам ойролцоогоор хэд болохыг тооцол. $P=P_0(1+(R/100)T)$ P_0 -тухайн жилийн хүн ам, R -жилийн дундаж өсөлт, T -тооцоолох жилийн тоо /3 оноо/

38. Хүн амын суваргыг ажиглан дараах асуултанд хариул /3 оноо /




А. Ямар хэлбэрийн суварга вэ?

Б. Ажиллах хүчний нөөц хэрхэн өөрчлөгдөх вэ?

В. Хэдэн насныхан хамгийн их хувийг эзэлж байна вэ?


39. Хүлэмжийн хий бууруулахад хувь хүний оролцоо юу байх вэ? Зурганд тайлбар хийнэ үү. /3оноо/



39-40. Хүчлийн бороонд өртсөн орнуудын зургийг ашиглан дараах даалгавруудыг хийж гүйцэтгээрэй. /4



Зураг а. Хүчлийн бороонд өртсөн орнууд оноо/



Зураг б. Химийн үйлдвэрлэлийн голлох төвүүд

3840.1 Хүчлийн бороонд өртөж буй үндсэн бүсүүдээс 2-г тодорхойл. /2 оноо/

4038.2 Хүчлийн бороо үүсэхэд нөлөөлж буй байгаль ба нийгмийн хүчин зүйлсийг ангилан бичээрэй. /2 оноо/

Баян-Уул ЕБС

2023-2024 оны хичээлийн жил

| № | Байгалийн шалтгаан | Нийгмийн (хүний үйл ажиллагаа) |
|---|--------------------|--------------------------------|
| 1 | | |
| 2 | | |

[Задгай даалгавар](#)